



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 4/105

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, “Журам шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажил үүргийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2021 оны 03 дугаар сарын 25-ны дотор хэлэлцүүлж, 03 дугаар сарын 30-ны дотор Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг ажлын хэсэг (Ц.Ганболд)-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100230

Аймгийн Засаг даргын 2021 оны...
дугаар сарын ...-ны өдрийн ... дүгээр
захирамжийн нэгдүгээр хавсралт



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА , ТҮҮНИЙ ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ
ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн ахлагч: Ц.Ганболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
Нарийн бичгийн дарга: Т.Үржинпүрэв (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-
шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга)
Гишүүд: Н.Энхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн дарга)
Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн дарга)
А.Отгонцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн дарга)
Э.Бадамгэрэл (Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн
дарга)
Ч.Батсуурь (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Н.Дулам (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Р.Цэрэндэжид (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн төсвийн ахлах мэргэжилтэн)
Л.Ишханд (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ,
үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Ц.Удвал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)
Н.Гуамарал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)
Х.Мөнхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ,
үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн)
И.Отгонцэнд (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ,
үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2021 оны...⁰⁵
 дугаар сарын 05-ны өдрийн...⁰⁵ дүгээр
 захирамжийн хоёрдугаар хавсралт

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛАХ
 АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд дараах зохион байгуулалтаар 2020 оны жилийн эцсийн тайланг 2021 оны 3 дугаар сарын 04-ний өдрөөс 3 дугаар сарын 30-ны дотор үнэлж, дүгнэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

1. **Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн:** Тайланг холбогдох хэлтэс (газар)-ээс нэгтгэн авч, мэдээллийг нягтлан шалгаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэлтсийн даргад танилцуулна.

2. **Хэлтсийн дарга:** Тухайн тайланг нягтлан шалгаж, гарын үсэг зурж баталгаажуулна.

3. **Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:** Тайланг хянаж, үнэлгээ өгнө. Хэрэв тайлангийн мэдээлэл, чанар хангалтгүй гэж үзвэл бодлогын хэлтсүүдээс дахин тодруулга авч үнэлгээг гаргана.

4. **Ажлын хэсгийн ахлагч:** Тайланг нягтлан хянаж, үнэлгээг 2021 оны 03 дугаар сарын 30-ны дотор эцэслэн баталгаажуулна.

Үзүүлэлт	Хяналт шинжилгээ хийх албан хаагч	Хянаж, үнэлэх хэлтсийн дарга	Тайлан хүлээн авч хянах албан тушаалтан	
Хугацаа	2021 оны 03 дугаар сарын 15-ны дотор	2021 оны 03 дугаар сарын 19-ны дотор	2021 оны 03 дугаар сарын 23-ны дотор	
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	2021 оны 1 дүгээр сарын 15-нд Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулж, аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 34 дүгээр албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт гаргах-Х.Мөнхцэцэг (ХШҮДАХ-ийн мэргэжилтэн)		
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	2021 оны 2 дугаар сарын 1-нд Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 2/52 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт гаргах-Ч.Батсуурь (ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн)		
	3. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт (аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл)	Үндэсний хөгжлийн газарт аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1/58 дугаар албан бичгээр тайланг хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт гаргах-Н.Дулам (ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн)		
	4. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	2021 оны 2 дугаар сарын 21-нд Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулж, аймгийн Засаг даргын 2021 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 1/118 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт гаргах-Ч.Батсуурь (ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн)		
	5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн	Х.Мөнхцэцэг (ХШҮДАХ-ийн	Т.Үржинпүрэв (ХШҮДАХ-ийн	Ц.Ганболд (ЗДТГ-ын

	үнэлгээ	мэргэжилтэн)	дарга)	дарга)
Байгууллагын чиг үүргийн үзэлдэлтийн үнэлгээ	1. Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	Гэрээний үүргийн биелэлтийг гэрээнд заасан хугацаанд холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлсэн. Гэрээний үүргийн биелэлтийн дүгнэлт гаргах-Ц.Удвал (ТЗУХ-ийн мэргэжилтэн)		
	2. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	Л.Ишханд (ХШУДАХ-ийн ахлах мэргэжилтэн) Ц.Удвал (ТЗУХ-ийн мэргэжилтэн)	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга)	Ц.Ганболд (ЗДТГ-ын дарга)
	3. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	Э.Бадамгэрэл (Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга)	Т.Үржинпүрэв (ХШУДАХ-ийн дарга)
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	Э.Бадамгэрэл (Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга) Н.Гуамарал (ТЗУХ-ийн мэргэжилтэн)	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга)	Т.Үржинпүрэв (ХШУДАХ-ийн дарга)
	2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	Р.Цэрэндэжид (СТСХ-ийн ахлах мэргэжилтэн)	Т.Үржинпүрэв (ХШУДАХ-ийн дарга)	Ц.Ганболд (ЗДТГ-ын дарга)
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ	А.Отгонцэцэг (ХЭЗХ-ийн дарга)	Т.Үржинпүрэв (ХШУДАХ-ийн дарга)	Ц.Ганболд (ЗДТГ-ын дарга)
Нэгдсэн тайлан	Засаг даргын Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны нэгдсэн тайлан, илтгэх хуудас	Дээрх мэргэжилтнүүд өөрсдийн хариуцсан бодлогын баримт бичиг, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үр дүнгийн талаар хяналт-шинжилгээний тайлан бэлтгэнэ.	Хэлтсийн дарга нар хянах	Н.Энхцэцэг (ТЗУХ-ийн дарга) Т.Үржинпүрэв (ХШУДАХ-ийн дарга)
	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан	Л.Ишханд (ХШУДАХ-ийн ахлах мэргэжилтэн)	Т.Үржинпүрэв (ХШУДАХ-ийн дарга)	Ц.Ганболд (ЗДТГ-ын дарга)
	Өвөрхангай аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд гарсан эерэг өөрчлөлт	Н.Гуамарал (ТЗУХ-ийн мэргэжилтэн)	Т.Үржинпүрэв (ХШУДАХ-ийн дарга)	Ц.Ганболд (ЗДТГ-ын дарга)
	Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн тайлан	Аймгийн дэд хөтөлбөрүүдийн 2016-2020 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг аймгийн Засаг даргын 2021 он 1/122 дугаар албан бичгээр баталгаажуулан, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд байршуулсан. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт тус бүрийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад аймгийн Засаг даргын албан бичгээр баталгаажуулан хугацаанд хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн дүгнэлт гаргах-И.Отгонцэнд (ХШУДАХ-ийн мэргэжилтэн)		